



**МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ**

2011 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 96

Улаанбаатар хот

Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн Газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн “Журам батлах тухай” 177 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”, “Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр тушаалаар батлагдсан “Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаадад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам”-ыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Гадаадад сургалтын төрийн сангийн зээлээр суралцуулах, тушаалд өөрчлөлт оруулах тухай” Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 475 дугаар тушаалын Ганхүүгийн Байгалмаатай холбогдолтой хэсгийн “Австрали Улсын Melbourne-ийн их сургуулийн магистрантурт Эрх зүйн чиглэлээр 1,5 жилийн” гэснийг “Английн Манчестрийн их сургуулийн магистрантурт Эрх зүйн чиглэлээр 1 жилийн ” гэж өөрчилсүгэй.

2. Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 5 дугаар сарын 14-ний 177 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаадын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчдад зээл олгох, эргэн төлүүлэх журам”-ын дагуу суралцагчтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Нансалмаа/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасгай.

САЙД



Ё.ОТГОНБАЯР